

## ЭМТ-ийн 2019 оны 5 -р сарын ажлын жагсаалт

№	Зорилт, арга хэмжээ	Хэрэгжилт
<b>Нэг. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ</b>		
1.1	Үндэсний хөтөлбөр старатегийн төлөвлгөөг хэрэгжүүлэх	ЭМТ-д хэрэгжиж буй Үндэсний хөтөлбөр старатегийн төлөвлөгөөний дагуу зохилон байгуулсан сургалт, үйл ажиллагаануудыг баримтжуулж, эрх зүйн сан бүрдүүллээ.
1.2	Хэнийгч орхигдуулахгүй явуулын амбулаторийн тусламж үйлчилгээг хөдөө багаар үзүүлэх	Хэнийг ч орхигдуулахгүй явуулын амбулаторийн баг хөдөө багаар явж эмнэлгийн тусламжийг үзүүлэх график төлөвлөгөөний дагуу Туяа багт 2 удаа бусад багуудад 1 удаа явж үзлэгээр 300 гаруй хүнийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулаад байна.
1.3	Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгүүдийг графикийн дагуу зохион байгуулах	Туяа багийн 40-64 насны иргэдэд Цусны даралт ихсэх өвчний эрт илрүүлэг, Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг, хөх, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг, элэгний вирүс ирүүлэх үзлэг , шинжилгээг зохион байгууллаа. Үзлэгт одоогийн байдлаар 126 иргэн хамрагдаад байна. Үзлэгийн үеэр Лабораторийн шинжилгээг хийлээ. Шээсний шинжилгээ 56, Сахарын шинжилгээ-22, хеликобактери/ш-33 ДОХ,Тэмбүүгийн тестээр-25 хүн шинжилгээнд хамрагдсан байна. Явуулын багаар 6 багт явуулын дархлаажуулалт хийж Улаан бурханы дархлаажуулалтыг 10-18 насны 168 хүүхдэд үзлэг хийж зөвөлгөө өгсөн.
<b>Хоёр .Зан үйлийн өөрчлөлт ба харилцаа</b>		
2.1	Сумын нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, НЭМ-ийн талаар төрөөс баримтлах бодлого, эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг салбар хоорондын хамтын оролцоотойгоор төлөвөлөн зохион байгуулж үр дүнг	Төрөөс нийгмийн эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 зэрэг эрх зүйн актуудыг үндэслэн Тарагт сумын эрүүл мэндийн төвийн хөгжлийн стартеги төлөвлөгөөг/2019-2023/ удирдлагын багаар хэлэлцэж баталлаа.

	тооцох	
2.2	Урьдчилан сэргийлэх үзлэгийн чанар хүртээмжийг сайжруулах/ нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт шаардлагтай иргэдийг хамруулах	Энэ сард БОЭТ-ийн явуулын баг ажиллах төлөвлөгөөтэй байсан ч уг ажил түр хойшлогдсон байна.
<b>Гурав.Хүний нөөцийн хөгжил”</b>		
3.1	Олон улсын сувилагч нарын өдрийг угтсан арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	Олон улсын сувилагч нарын баяр угтаж Онол практикийн баг хурлыг зохион байгуулж явууллаа. Мөн сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулая аяны төлөвлөгөөний дагуу үйл ажиллагнуудыг зохилн байгуулж ЭМГ-т тайлганасан.
<b>Дөрөв.” Эрүүл мэндийн санхүүжилт”</b>		
4.1	Төсвийн ил тод нээлттэй байдлыг сайжруулах	Төсвийн ил тод нээлттэй байдлыг сайжруулах зорилгоор сар бүр төсвийн мэдээллийг ажилчдын хуралд танилцуулж,ЭМГ-ийн санхүүч манай байгууллага дээр ажиллаж олон жил тогтвор суурьшилтай ажиллаж байгаа зарим эмч мэргэжилтнүүдийн цалингийн шатлалыг 1-р ахиулж тогоочид ур чадварын нэмэгдлийг, хүүхдийн эмч, эмэгтэйчүүдийн асуудлыг хариуцан аажиллаж буй эмч мэргэжилтнүүдэд ЗГ-ын тогтоолын дагуу 10-ийн урамшуулал нэмж олгох эрхийг олголоо.
4.2	Өдрийн эмчилгээ болон гэрийн сувилахуйн тусламж үйлчилгээг иргэнд тэгш хүртээмжтэй хүргэх	Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэх шаардлагтай иргэдэд сувилахуйн тусламж хүргэх Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 08 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт, ЭМС-ын 2017 оны А/41 тушаалаар заагдсан сувилахуйн тусламж үйлчилгээний талаар сургалтыг зохион байгуулж 30 иргэнд гэрийн сувилахуйн тусламж үзүүлсэн байна.Өдрийн эмчилгээнд 50-д иргэнийг хамруулсан ба гэрийн сувилахуйн тусламж үйлчилгээг хэвтрийн болон хавдрын улмаас хөнгөвчлөх тусламж үйлчилгээ шаардлагтай 17 иргэнд хийж , Нөхөн сэргээх, оношлогоо шинжилгээ, өдрийн

		эмчилгээг заасан хуваарийн дагуу хүмүүсээ хамруулсан байна.
Нэмэлтээр хэрэгжүүлэх хөтөлбөр төлөвлөгөө		
5.1	Тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жилийн төлөвлөгөөний дагуу ЭМТ-ийн доторх хайс хашлагыг шинэчилж төмөр хайсан хашааг 1600,000 мянган төгрөгөөр бариулж, 60 ш шар хуайсыг суулгалаа. Цаашид төлөвлөгөөний дагуу ажлуудыг үргэлжүүлэн хийж байна.
5.2	Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил болгон зарласантай холбогдуулан 6 багийн хуралд оролцож орон нутгийн хөгжлийн хөрөнгө оруулалтын саналд эрхлэгч эмч Д.энхбаатар саналаа танилцуулж ЭМТ-ийн үйл ажиллагааны талаар товч мэдээллийг тухай бүр өгч, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг баг дээр нь зохион байгууллдаа./160 орим иргэд хамрагдсан байна.
5.3	Инээмсэглэл эерэг хандлага-аян өрнүүлэх	Инээмсэглэл эерэг хандлага-аян өрнүүлж, Эмч мэргэжилтнүүд энгэрийн тэмдэг , дүрэмт хувцсаараа жигдрэн Аймгийн засаг даргыг ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хүлээн авч ЭМТ-ийн үйл ажиллагаатай танилцуулан, мөн УБ хот дахь нутгийн зөвлөл, Өвөрханай аймаг дахь нутгийн бүрэлдэхүүнийг хүлээн авч байгууллагынхаа үйл ажиллагааг танилцууллаа. Манай байгууллагын дотоод тохижилт , цэвэрлэгээ үйлчилгээ, хамт олоны уур амьсгал, үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байна гэдгээ ажлын хэсгийн бүрэлдэхүүнүүд илэрхийлсэн байна.
5.4	Эх, хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулахад “Иргэдийн оролцоо” сэдэвт нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулах	Эх, хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулахад иргэдийн оролцоо сэдэвт нээлттэй хаалганы өдрийг явуулж, эцэг эхчүүдэд тусламж хайх мэдлэг олгох сургалтыг 1 удаа зохион байгуулж 0-2 насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд хүүхдийн эхний 1000 хоног сэдэвт сургалтыг зохион байгууллаа.28 эцэг эх хамрагдсан байна.
5.5	Бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ хайх, хүүхэд хамгааллын мэдлэг	

	олгох сургалтыг 2 удаа зохион байгуулах	
5.6	Ядуу эмзэг болон хөгжлийн бэрхшээлтэй эх, хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээр үзүүлэх	Явуулын багаар явах үедээ өндөр настан 28, хөгжлийн бэрхшээлтэй 33, ядуу өрхийн-15 иргэнд явуулын амбулаторийн тусламж үзүүллээ.
5.7	Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдэд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх видео кино үзүүлэх , гарын авлага боловсруулан түгээх	Хүлээлгийн танхимд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх видео хичээлийг тогтмол явуулж байна/ цусны даралт , чихрийн шижин, хүүхдийн хоол тэжээл, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд/

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН СМА

Ж.НЯМДУЛАМ

ХЯНАСАН.ЭРХЛЭГЧ ЭМЧ

Д.ЭНХБААТАР